

ПАРЛАМЕНТЫН ЁС ЗҮЙН СУДАЛГАА БА ХӨГЖИЛ

Д.УИДРАХ

Доктор МУИС, ШУС, Нийслэлийн эрх зүйн сургууль
Хэс Төгсөв, Увсанг Дамбал

Түлхүүр үг: Парламентат ёс, ёс зүй, ёс зүйн дүрэм

Товч утга: Ардчиллын бэхжилт, парламентат ёсны төлөвшил, засаглалын үр дүртэй, тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцлага, ёс зүйгүйгээр төсөөлөхийн аргагүй. Эрх зүйт төрийг цогцлоон байгуулах ажлын суурь үндэс хууль тогтоогчдын ёс зүйн хэм хэмжээний ёс зүйн зохицуулалт хяналтын тогтолцоог бүрдүүлэхтэй нягт уяллана.

Abstract: Since its democratic transition started in early 1990s, Mongolia has achieved relatively well in establishing democratic institutions and making legal reform. Institutional part of reform is on the way of process with its success and failure, and this part of work has been examined and surveyed in some extent by local and foreign experts and researchers. Even though, subjective factors that appear through tradition and cultures and, value and assessment system of individuals in a society are not considered and less recognized during this era of transition. Then when we face failures of reform, instability of socio-economic life and “back wave threat” to democracy, we start to seek the “missed and changed” regulatory effect of ethical and moral norms. Especially, the ethics of law makers are crucially important to be regulated and enforced.

Монгол оронд өрнөсөн ардчилсан шилжилтийн үйл явц нийгмийн амьдралын гүнхий л хүрээнд өөрчлөлт, шинэчлэлт авчирсаны дээр ойлголт, үнэт зүйлсийн тогтолцоонд ч мэдэгдэхүйц ялгаа бий болоход нөлөөлж байна. Иргэний ардчилсан нийгэм, эрх зүйт төрийг цогцлоон хөгжүүлэх үйл хэргийг тогтолцооны хүрээнд, бүтцийн шинжтэй хэрэгжүүлэх гэж хичээж боломжийн амжилтанд ч хүрээд байна. Гэвч нийгмийн үнэт зүйлсийн тогтолцоонд хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааг ёс горим, хэм хэмжээнд чиглүүлж байдаг зохицуулагчийн үүрэгтэй ёс суртахууны үүрэг, ач холбогдлыг үл хэрэгсэн өнөөг хүрсэн явдал эдүгээ тулгарч буй олон бэрхшээл саад, зогсонги байдлын үндэс болж байгааг одоо л бид анзаарч, ярих боллоо. Парламентат ёс үүсч хөгжсөн олон зууны түүхэнд түүний ёс зүйн стандарт, ёс зүйн зохицуулалтын олон талыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан төгцлээн цогц бүтээлүүд хангалттай бус ч зарим асуудлууд нь тодорхой хэмжээгээр судалгааны эргэ, тэд орж, эрдэмтэд судлаачдын судалгаа, бүтээлд дурдагджээ. Мэргэшсэн парламентын үйл ажиллагаа нь мэдээлэл тоглогчдыг ёс суртахуунлаг зан харилцаатай байх шаардлага тавьдаг. Парламентын хуралдааны ганхмд гишүүн нь бусад гишүүдтэй зүй бус, зохисгүй харьцахгүй байх ёстой боловч болит амьдрал дээр танхимын нөхөлтэйгээ зөрчилдөх, олонхийн санаа бодлыг үл тоомсорлох асуудал элбэг тохиолддог. Иймэрхүү үйл байдлын шалтгаан олон хүчин зүйлээс хамааралтай. Тухайлбал, Оросын ёс зүйн судалгааны томоохон төлөөлөгчид болох Р.Апресьян, В.Бахитановский, Ю.Согомонов нар парламентын ёс зүйг философич, эрх зүй, улс төр судлалын хандлагаар тайлбарлахыг шаарддаг поликультур үзэгдэл (субкультур дундын судлагдахуун) хэмээн тодорхойлж, төв суртахуунтай улс төрчийн ёс суртахууны нарийн төвөгтэй үзэгдэл анхаарал хандуулалттай байдаг. Апресьян “Парламентын ёс зүйн ойлголт ба түүнийг бүрдүүлэх боломжит арга замууд”¹ огүүтэлд: “парламентын ёс зүйг мэргэжлийн ёс зүй, мэргэжлийн ёс зүй, субъект-тодорхой ажиллагааны ёс зүй гэрэг компонентоос бүрдэх “синтетик зохицуулалт-үнэтэмжийн феномен” хэмээн тодорхойлсон нь бий. Судлаачдын судалгааны ажлын чиглэл, зохиол бүтээлээс харахад олонхи нь парламентын ёс зүйн гол хоёр асуудал болох парламентын үйл ажиллагааны чиглэл байнга үүсдэг ёс суртахууны сонголт ба ёс суртахууны үнэтэмжийн парадокс асуудлуудыг анхааралтай хандуулжээ. Тухайлбал, энэ талаар Английн орчин цагийн улс төр судлалын томоохон төлөөлөгчид болох В.Гай, М.Раш, П.Леопольд, А.Дойт, П.Ричардс, Д.Глазнер нар эрх зүйн талаар нь судалж, парламентын ёс зүйн дүрмийг зорчсон томоохон кэйс судалгаанууд, ёс зүйн дүрмийн бүтэц, агуулгын шинжилгээгүүдийг хийсэн байдаг. Эдгээр судлаачид парламентын эрх зүйн дотоод хэм хэмжээнүүд дээр үндэслэн Их Британийн Парламентын үйл ажиллагааны олон зууны түүх бүхий өөрөө өөрийгөө зохицуулах тэгшитгэлийн нь парламентын ёс зүйн асуудлыг холбоон тайлбарласан байдаг. Тэд Английн парламентын үйл ажиллагаанд ёс зүй-эрх зүйн зохицуулалтын зарим нэг ололттой талууд болох гишүүд бие биедээ хүндэтгэлтэй хандах, бусдын байр суурьт хүлээцтэй хандах, өөрийн

¹Апресьян, Р.Г. Особенности парламентской этики и возможные пути ее формирования //Парламентская этика в России сб. материалов Комиссии Государственной Думы Федерального Собрания Российской Федерации по этике. М., 2002/

байр суурийг ойлгомжтой, ухаалгаар илэрхийлэхэд нь боломж олгох, бусдыг сонсож сурах зэрэг бусдад үлгэрлэхүйц олон сайн тал байдгийг цохон тэмдэглэсэн байдаг.

Парламентат ёсны хөгжил, туршлага бага манайх шиг улс орнуудад парламентын легитимчлэл хийгээд гишүүдийн ёс зүйн дүрэм боловсрох, хэвших зэрэг суурь олон асуудал нилээд удаан бөгөөд ээдрээтэй замыг туулдаг нь түгээмэл ажээ. Энэ бүхэн нь эдүгээ ардчилсан нийгэм дэх ёс суртахууны стандартыг дээшлүүлэх ерөнхий хэрэгцээ, шаардлагаар нөхцөлдөн гарч ирдэг. Легитимт байдал гэдэг парламентын сэтгэл зүйн чухал хүчин зүйлийн нэг бөгөөд засаглалын институцүүдэд хандах иргэдийн хандлага ч үүн дээр суурилдаг. Орчин үеийн ардчилсан хөгжлийн үйл явцыг тодорхойлохдоо зарим эрдэмтэд үүнийг “ардчиллын этос буюу ардчилсан ёс суртахууны төлөвшил/дадал заншил”² хэмээн тодорхойлсон нь бий. Энэ утгаараа сэтгэл судлаачид, улс төр судлаачдын анхаарал, сонирхол улс төрийн ёс зүйн асуудал руу ихээр хандах болж, парламентын үйл ажиллагааны эрх зүйн болон ёс зүйн зохицуулалт, түүний адилсал, бүрдүүлэлтийн асуудал улс төрийн шинжлэх ухаан, улс төрийн практик асуудлуудын төвд тавигдах болж байна.

Парламентын үйл ажиллагааны маш чухал бүрдлийн нэг бол түүний ёс зүйн болон эрх зүйн зохицуулалтын асуудал гэдгийг өмнө дурдсан билээ. Энэ нь хэд хэдэн хүчин зүйлсээр нөхцөлдөг. Үүнд:

- Парламентын гишүүний үйл ажиллагаа нь олон нийтийн янз бүрийн санаа бодол, ашиг сонирхолыг багтаасан бөгөөд илэрхийлж чадахуйц байх ёстой тул сонгогчдынхоо өмнө ёс суртахууны өндөр хариуцлага хүлээхийг шаарддаг.

- Парламентын үйл ажиллагаа нь гишүүд, сонгогчид, хэвлэл мэдээллийнхэн, гадаадын төлөөлөгчид, төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчид зэрэг олон тооны хүмүүстэй байнгын харилцаа, хамтын ажиллагаа, харилцан нөлөөлөлд орж байдаг тасралтгүй өрнөх үйл явц юм.

- Мэргэшсэн парламентын ёс зүй нь зөвхөн хувь хүний итгэл үнэмшил, гишүүдийн ёс суртахуун болон сэтгэл зүйн үйлдэл, нөлөөлөл төдий бус парламентын хууль, дүрэм журмын нэгдмэл цогц билээ.

- Ёс зүйн стандартын төвшин нь олон талаараа парламентын үйл ажиллагааны үр дүнтэй байдалд нөлөөлдөг. Тухайлбал, хууль тогтоогчдын хариуцлагын ухамсар, төрийн хууль тогтоох, бодлого боловсруулах үүрэг, сонгогчдодоо хандсан үйл ажиллагааны үр нөлөөтэй байдал зэрэг олон асуудалд шууд болон дам нөлөөлөх билээ.

Иймээс парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх нэг чухал арга бол парламентын ёс зүйн үндсийг бүрдүүлэгч ёс зүйн дүрэм, хэм хэмжээний системийг бий болгох явдал гэж үзэх болжээ. Гэвч улс төрийн соёл хийгээд ёс зүйн ач холбогдлыг үл ойшоох хандлага нь хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны доголдол, үр дүнгүй, хэт үрэлгэн байдал, парламентын тогтолцооны нэр хүндийн уналт зэрэг олон таагүй үзэгдэл, үр дагаварт хүргэж байна.

Парламентын ёс зүйн дүрмийг янз бүрээр тайлбарладаг. Үүнийг нэг талаас гишүүдийн үйлдэл бүрийг зохицуулсан хатуу журам гэж үздэг бол, нөгөө талаар шаардлагатай зөвлөмжийн цогц гэх нь ч бий. Жишээлбэл, АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимийн гишүүдэд зориулсан 400 гаруй хуудас зөвлөмж байдаг аж. Тэр бүхэн нь Конгрессын үйл ажиллагааны бүхий л талыг тухайлбал, зан үйл, ёслол, хуралдааны үеийн хэлэлцүүлэг, санал хураалт, илтгэл, хэлэлцүүлгийн үеийн хориг зэрэг олон тооны чухал зохицуулалтад хэрэглэгддэг.

Орчин үеийн нийгэм нь нарийн, тусгай мэдлэг чадварыг эзэмшсэн мэргэжилтнүүдийн ур чадвараар хөгжиж байна. Нийгэмд “мэргэших” хандлага нь урьд хожид байгаагүй их бие даасан байдал буюу өөрөөр хэлбэл, өөрийн гэсэн ёс зүйн хэм хэмжээ бүхий мэргэжлийн бүлгүүдийн автономн байдлыг бий болгож байна. Парламентын ажлыг либерал / чөлөөт ажил гэх нь бий. Уламжлалт ойлголтоор бол либерал мэргэжлүүд илүү эрх чөлөө, бие даасан байдалтай байдгаараа худалдаа ч юм уу, бизнесийнхнээс ялгаатай гэгддэг. Энэ бүхэн нь нийгэм өөрөө тэдгээр либерал ажил мэргэжлүүдийг хянахад хүчин мөхөсдөж оронд нь нийтийн сайн сайханд үйлчилдэг байх, мэргэжлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, нийгмийн бусад хэсэгтэй харьцуулахад үйл байдал, ёс суртахууны өндөр стандартыг бүрдүүлэхийг шаарддаг болсоноор тайлбарлагдана. Нийгмийн хяналт суларч буй явдлын нөгөө талд аливаа ажил мэргэжил өөрийн гэсэн дүрэм, сахилгын журам, мэргэжлийн болон өрсөлдөх ур чадварын стандарттай байх ёстой гэсэн шаардлага гарах болов. Мэргэжлийн бие даасан байдлын ёс зүйн бас нэг тал нь тусгай мэдлэгтэй байх, тэрхүү мэдлэгт хүрэх онцгой боломжийг эзэмшдэг байх явдал юм. Тэгвэл парламентын гишүүдийн хувьд энэхүү мэргэжлээр олгогдох давуу талаа нийтийн төсвөөр


² Этос-ыг “дадал заншил” гэж орчуулах нь түүнийг зүй ёсны зохиомол хэм хэмжээнээс ялган харуулахад тохиромжтой юм хэмээн Монголын нийгмийн өөрчлөлт /хамтын бүтээл. УБ., 2008. 120 дахь тал/ бүтээлд бол, “орчин үед ёс суртахууны төлөвшлийг илэрхийлэх болжээ.” /Золзаяа М. Ёс зүй. 2008. 29 дэх тал./

хувийн сонирхолоо гүйцэлдүүлэхэд ашиглаж мэдэх орон зай үүсэхээс сэргийлэх ёстой. Парламентын гишүүний ажил нь өөрөө нийгмийн либерал ажил мэргэжлүүдийн нэг мөн болохын хувьд өөрийн гэсэн тодорхой дүрэм, зарчим, хэм хэмжээ, хяналт, зохицуулалтын системтэй, мэргэжлийн стандарт, зан үйлдэл, ёс зүйн дүрэмтэй байна. Парламентын үйл ажиллагаа, ёс зүйн стандартын журам нь ардчилсан тогтолооны үр нөлөө, ил тод хийгээд тэгш байдал, улмаар хувийн сонирхлоос илүү нийтийн ашиг сонирхлыг хангах төрийн үйлчилгээний соёлыг хөгжүүлэх, тэдгээрт итгэх иргэдийн итгэл үнэмшлийг хангах нэн чухал элемент юм.

Парламентын үйл ажиллагааны дүрэмтэй холбоотой янз бүрийн зохицуулалтын загваруудаас нэн түгээмэл нь “Ёс зүйн дүрэм” нэртэй парламентын гишүүдийн үйл байдал, ёс зүйн хүлээн зөвшөөрөгдөх стандартуудыг багтаасан дүрэм юм.³ Парламентыг тойрсон дуулиан, шуугианууд нь өргөн хүрээтэй, ил тод, зөвлөмжийн шинжтэй ёс зүйн зохицуулалтыг шаардах боллоо. Тухайлбал, Европын Холбооны гишүүн улсуудын хувьд л гэхэд үндэсний Парламентуудад итгэх иргэдийн итгэл 2007 онд 57 хувь байсан бол, 2012 онд 51 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. (График 1). Судалгаанаас харахад, иргэдийн иймэрхүү сөрөг дүгнэлт, санаа бодолд санхүүгийн байдал, ашиг сонирхлын зөрчил, гишүүдийн парламентын болон салбар хороодын хуралдааны ирц, оролцоо, мэдээллийн буруу хэрэглээ, Парламентын гишүүний хувьд тойрогтоо зарцуулах хөрөнгийг буруугаар ашиглах зэрэг зүй бус үйлдлүүд нөлөөлдөг ажээ. Тухайлбал, доорхи графикаас Европын Холбооны улсуудын ард иргэдээс улс төрчдийг авлигад автсан эсэхэд өгсөн үнэлгээг харж болно.⁴ Иргэдийн үнэлгээгээр Болгар-76%, Грек-74%, Ирланд-71%, Испани-70 %-тай тэргүүлж байгаа бол, Дани улсын иргэд 25% буюу хамгийн бага хувийг өгч өөрийн орны улс төрчдөл өндөр итгэл хүлээлгэдэг гэдгийг харуулжээ. Судалгаанд хамрагдсан 27 орноос дийлэнх олонхи буюу 50-иас дээш хувь нь улс төрчдийг авлигад автамттай гэж хариулсан нь асуудал ноцтой болохыг харуулж байна.

Европын Холбооны улсуудын иргэдээс өгсөн улс төрчдийн авлигын талаарх судалгаа

График 1.



Эх сурвалж: European Commission, *Public Opinion In the European Union-First Results*, Standard Eurobarometer 77, Spring 2012, p. 23.

<http://ec.europa.eu/public_opinion/archives/eb/eb77_first_en.pdf>

Ихэнхи улс орнуудад Үндсэн хууль болон холбогдох бусад хууль, журмаар (төрийн албан хаагчийн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлийн эерэг хууль, хөрөнгө орлогын мэдүүлтэг, Эрүүгийн хууль, захиргааны хууль г.м.) парламентын гишүүдийн үйл ажиллагаа, ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьдаг байна.

³“Code” - гэрх зүйн өөр өөр уламжлалтай улсуудад “кол” гэдэг үгийг ялгаатай тайлбарладаг. Иргэний эрх зүйн уламжлалд “хууль эрх зүйн нэгдсэн баримт бичиг” гэж ойлгодог бол, нийтийн эрхзүйн системд “хэлэлцэн тохирсон албан бус зохицуулалт” гэдэг. “Вестминстерийн Ардчиллын Сан”)

“Code of conduct”, “code of behavior” and “code of ethics”-заримдаа харилцан орон хэрэглэгддэг бөгөөд ялгаатай хэлнүүдэд өөр өөр утгатай хэрэглэгдэхийг үгүйсгэхгүй. Code of Conduct-Ёс зүйн дүрэм гэсэн орчуулгаар Даваадулам Засаглалын үзэл баримтлал. Нэр томъёоны тайлбар толь бичигт оруулаан байна

⁴ http://ec.europa.eu/public_opinion/archives/ebs/ebs_325_en.pdf

Өнгөц харахад, батлагдан гарсан хууль журмын тоогоор бол дахин шинэ хууль эсвэл дүрэм нэмж батлах, мөрдүүлэх онц шаардлагагүй, одоо байгаа нь хангалттай мэт харэгддаг. Хэрэг дээрээ, тэдгээр нь шаардлага хангаад, зүй зохистой байгаа бол үнэхээр ч шаардлагагүй. Гэвч бодит байдал дээр дутагдалтай байгаа парламентын орчныг эрүүлжүүлэх, төр засагт итгэх иргэдийн итгэл, төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоо, сонгогчдын сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх, иргэдийн хяналт, иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой, хяналтыг бодитой болгох, дөрөв дэх засаглал хэмээгдэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодит оролцоо хяналтыг сайжруулах улмаар төрийн албыг мэргэшсэн, өндөр ёс суртахуунтай төрийн түшмэлдээр хангах нэн чухал алхамын нэг бол Парламентын ёс зүйн дүрмийг тусгайлан баталж мөрдүүлэх явдал юм.

Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг стандарттай болгох талаар хийсэн алхмуудын дотор лорд Ноланы санаачилгаар Их Британид 1994 онд нэвтрүүлсэн төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм⁵ зүй ёсоор орно. Хэдийгээр Их Британы нөхцөлд тохируулан боловсруулсан боловч тус дүрэмд улс төр, түүх, соёлын ялгаанаас үл хамааран улс орнуудын төрийн албанд мөрдөж болох нийтлэг 7 зарчмыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Хувна бодохгүй байх-төрийн албанд ажиллагсад зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргаж байх. Өөрсдийн болон гэр бүл, найз нөхдийнхөө санхүүгийн болон материаллаг бусад сонирхлын үүднээс шийдвэр гаргах явдлыг хориглох;

2. Зарчимч байх-төрийн албанд ажиллагсад хувь хүн, байгууллагын өмнө албан үүрэгтээ сөргөөр нөлөөлж болох санхүүгийн болон бусад амлалт үүрэг авахгүй байх;

3. Бодитой хандах-албан тушаалд томилж, гэрээ, хэлэлцээр байгуулах, шагнал урамшуулал, тэтгэлэгт тодорхойлох зэрэгт зөвхөн ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадвар, гавьяа зүтгэлд үндэслэсэн сонголт хийх;

4. Хариуцлагатай байх-төрийн албан хаагчид гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байх, аливаа хяналт, шалгалтаас зайлсхийхийг хориглох;


5. Нээлттэй байх-төрийн албан хаагчдын гаргаж байгаа шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ аль болох нээлттэй, гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг олон нийтэд ил тод мэдээлдэг, мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашигт илэрхий харшилсан тохиолдолд хязгаарладаг байх;

6. Шударга байх-төрийн албан хаагчид нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс албан үүрэгтэй нь харшлах хувийн сонирхлынхоо талаар мэдээлж, сонирхлын зөрчилгүй ажиллах;

7. Манлайлах-төрийн албан хаагчид эдгээр зарчмыг мөрдүүлэх үйл хэрэгт манлайлал, үлгэр дуурайлал үзүүлэх явдал орно.

Парламентын гишүүдийн ёс зүйн стандартыг хэвшүүлэх, сайжруулан боловсруулах ажлын ач холбогдлыг дараах байдлаар томъёолж байна (Зураг 2).

Зураг 2.



⁵ Nolan Principles-Их Британийн Төрийн албаны Стандартын Хороондос анх 1994 онд баталсан зарчим. Даваадулам Ц. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичигт “зан суртахууны дэлгэрэнгүй дүрэм” гэж орчуулагдсан байна. 2010. 23 дахь тал

Авлига, хээл хахуультай тэмцэх-Хэвшнж тогтсон найдвартай, зөв дүрэм журам гэдэг албан ажлын явцад гарах зөрчил дутагдал, авлигын олон хэлбэрээс зайлсхийхэд туслах төдийгүй хууль боловсруулагч түшээдийн зохистой үйл байдал, зан суртахууны хэм хэмжээг тогтоон өгч, улмаар зохицуулалт, хяналтын механизмыг бүрдүүлж, зөрчил дутагдлыг арилгах сахилга, шийтгэлийн журмыг ч багтаадаг. Парламентын гишүүн байна гэдэг нэр хүндтэй ч, өндөр хариуцлагатай ажил тул тэр хирээрээ элдэв асуудалд холбогдох магадлал өндөр байдаг аж. Тодорхой бөгөөд тууштай мөрддөг стандарт, дүрэм нь ард түмний хүлээлт хийгээд аливаа санамсаргүй алдаа эндэгдлийн цаашдын үр дагаврын талаар тодорхой ойлголт мэдээлэл өгөхөд чиглэгддэг байх ёстой. Иймээс ёс зүйн доголдоос үүдэлтэй авлига, хээл хахуультай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлын эрх зүйн зохицуулалт болж өгдөг гэдэг утгаараа ёс зүйн дүрэм ба холбогдох хууль, дүрэм журам чухал ач холбогдолтой. Гэхдээ аливаа дүрэм журам, зохицуулалт гэдэг хууль тогтоох байгууллагын дотоод хэм хэмжээ, үйл ажиллагааны хэвийн байдалд нөлөөлөх, саад учруулах, түүнтэй зөрчилдөх ёсгүйг мартаж болохгүй.

Легитимчлэл ба хариуцлагыг нэгилүүлэх-Иргэд сонгогчдоод болоод хэвлэл мэдээллийнхэнд хариуцлага тооцох, хяналт тавих жишиг ба хамрах хүрээг тогтоож өгсөнөөр ёс зүйн зохицуулалтын систем үнэн зөв, үр дүнтэй ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, төр засгийн үйл ажиллагаанд итгэх итгэл, сонгогчдын дэмжлэг нэмэгдэх юм.

Мэргэжлийн үр чадвар⁶-Парламентын гишүүд гэдэг янз бүрийн мэргэжил, давхаргыг төлөөлөн хууль тогтоох байгууллагад сонгогддог бөгөөд энэхүү ялгаатай байдал нь сонгогчдыг төлөөлөх үндсэн үүргийн хувьд нэн чухал шалгуур мөн билээ. Гэвч, нэгэнт парламентад сонгогдсон тохиолдолд хуульч, эмч нар мэргэжлийн стандарт мөрддөгийн адил төрийн албаны нэгдсэн дүрэм журамд захирагдах ёстой гэдгийг мэддэг байх нь зүйтэй. Холбогдох дүрэм журам ойлгомжтой, оновчтой байх нь гишүүдийг ч нэгдэн нягтрах, тодорхой улс төрийн ялгаагаа даван туулах, хамтач сэтгэлгээ, зөвшилцлийн соёлыг бүрдүүлэх, улмаар төрийн албаны нэр хүндийг өргөх, чадварлаг иргэд-сонгогчдыг уг албанд татагдах, улс төрийг сонгох, сонирхлыг нэмэгдүүлэхэд нэн чухал юм.

Олон улсын жишигт нийцэх-Хууль тогтоогчдын ёс зүйн дүрэм оновчтой, тодорхой болсноор тэдгээрийн нэгдмэл байдал, шударга зан төлөв, хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлэх төдийгүй олон улсын нэгдмэл стандарт, хэм хэмжээг хүндэтгэн сахих, биелүүлэх тухайн улсын олон улсын төвшин дэх нэр хүндэд ч багагүй ач холбогдолтой.

Дэлхийн бүх улс орнуудын хууль тогтоох байгууллагуудад мөрдөх ёс зүйн нэг стандарт, жор гэж байхгүй боловч аль ч улс оронд өөрийн засаглалын хэлбэр болон улс төрийн нөхцөл байдлаа харгалзан үзэж улс төрийн тогтолцооны суурь асуудал, эрсдэлтэй талыг тодорхойлох замаар олон улсын стандарт, үндсэн хуулийнхаа агуулга, хэрэгжиж буй хуулиудтай уялдуулан парламентын дэг, ёс зүйн дүрмийг боловсруулан мөрдөх нь зүйтэй.

Парламентын гишүүний ёс зүйн дүрэмд хамрах асуудал, шийдвэрлэх арга хэлбэрт ч анхаарвал зохих асуудал олон байдгаас эрх зүйн зохицуулалтын зааг хязгаарыг тогтоохдоо: Парламентын гишүүдийн хувийн амьдралыг хэрхэн зааглах: Парламентын гишүүний халдашгүй дархан байдлын тухай асуудлууд бүрхэг үлддэгээс олонх тохиолдолд “хуулийн цоорхой” гэгдэх зохицуулалтгүй асуудал, хяналтгүй орчин бий болох магадлал, эрсдлийг ихэсгэдэг.

Хариуцлага, ёс зүйгээрээ нийгэмд үлгэрлэвэл зохих хууль тогтоогчдын ёс зүйн асуудлын эргэн тойронд шийдвэрлэвэл зохих, эрх зүйн зохицуулалт хүлээсэн олон асуудал байгаагын зөвхөн нэгээхэн хэсгээс цухас дурдахад ийм байна.

⁶ Professionalism/Мэргэжлийн хандлага, үр чадвар-Нийгмийн зүгээс “мэргэжилтэн” хэмээн хүлээн зөвшөөрсөн аливаа этгээд ажил үүргээ гүйцэтгэхдээ баримтлах хандлага, үр чадвар, зан суртахуун, шинж чанар, эрхэмлэх зүйлсийн нэгдлийг илэрхийлсэн нэр. Даваадулам Ц. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг 2010. 83 дахь гал

Ангир: Эрдэнэ номын жагсаалт

1. Аристотель. “Никомаховын ёс зүй” Орч.Б.Даш-Ёндон. УБ., 2007
2. Аристотель. “Дээд суртахуун” Орч.Б.Даш-Ёндон. Адмон. УБ., 2008
3. Дашжамц Д. Дарьхүү А. Золзаяа М. “Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх” ШУА. УБ., 2009
4. УИХ-ийн гишүүний ёс зүйн дүрэм (2009)
5. УИХ-ын ёс зүйн дэд хорооны дүрэм (2010)
6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012)
7. The Bulletin, Oct14. 1997. Quoted in Andrew Brien, “A code of Conduct for Parliamentarians?” report prepared for the Parliament of Australia, Sep 14. 1998. p.5.
8. United Kingdom House of Commons, Parliamentary Commissioner for Standards. “Review of the Code of Conduct for Members of Parliament: Consultation paper”, 2011,
9. Ethics in Politics: Why it matters more than ever and How it can make a difference. Benoit Girardin, Geneva, 2012
10. Santa Clara University, Markkula Center for applied ethics [http://scu.edu/ethics/practicing focus areas/ government_ethics](http://scu.edu/ethics/practicing_focus_areas/government_ethics)